



НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТАТВАР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ  
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ХӨНДЛӨНГИЙН БАЙГУУЛЛАГА  
**“АЙ ЖЭЙ ЭЙ ЭЙЧ-АУДИТ” ХХК**

2019 оны 12 сарын 31 өдөр

№ 02

Улаанбаатар хот

**“ЖУУЛЧИН ГОВЬ” ХК-ний захирал Б.Гантулга танаа**

**Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан**

“ЖУУЛЧИН ГОВЬ” ХК-ний 2019 оны 12-р сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон хугацааны орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдэх санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “ЖУУЛЧИН ГОВЬ” ХК-ний 2019 оны 12-р сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайлан, үйл ажиллагааны үр дүн, өмчийн тайлан, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын олон улсын стандартад зохицуулан үнэн зөв толилуулсан байна.

**Аудитын дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлага энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудиторын хүлээх хариуцлага гэсэн хэсэгт харууллаа.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

**Аудитын гол асуудлууд**

Бидний мэрэгжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэдэг нь тайлант үеийн санхүүгийн иайланд хамгийн их нөлөөтэй болно. Санхүүгийн иайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг илтгэсэн байдлаар авч үзсэн ба тусдаа дүгнэлт гаргаагүй болно.



### Санхүүгийн тайлангийн талаарх компаний удирдлагын хариуцлага:

Санхүүгийн тайланг санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж үнэн зөв толилуулах нь удирдлагын хариуцлага. Алив алдаанаас үүсэн материалаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэж үнэн зөв гаргахтай холбогдсон дотоод хяналтыг хэрэгжүүлэх, нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогыг сонгож хэрэглэх зэрэгт энэхүү хариуцлага хамаарна. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компаний тасралтгүй явуулах хариуцлагаа хүлээнэ.

### Санхүүгийн тайлангийн талаарх аудиторын хариуцлага

Аудиторын үүрэг бол гүйцэтгэсэн аудитынажилдаа тулгуурлан санхүүгийн тайланд дүгнэлт гаргах явдал. Аудитын дүгнэлтээ бид аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэн, дүгнэлтээ гаргах явдал.

Аудитын үед санхүүгийн тайлан дахь дүн мэдээ болон тодруулгын тала

ар аудитын нотолгоо олж авахад чиглэсэн горимыг баримтлана. Ингэхдээ элдэв буруу байж болох эрсдлээс сэргийлэхэд анхаарах нь зүйн хэрэг. Энд мөн тухайн байгууллагын дотоод хяналтын ач холбогдлыг анхаарах нь зүйн хэрэг


Мөн нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компани үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах боломж, материалаг бус байдал байгаа эсхийг тодорхойлно

### Тайлангийн хэрэглээ

Бид энэхүү аудитын дүгнэлтээ **"ЖУУЛЧИН ГОВЬ"**

ХК –ний эзэмшигчид зориулж бэлтэсэн. Тайлангийн агууллагын хүрээнд өөр алив нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

АЙ ЖЕЙ ЭЙ ЭЙЧ аудит компани.



Тайлангийн дүгнэлт үйлдсэн аудитор.....

. 2020-02-02-ний өдөр

КОМПАНИЙ МЭДЭЭЛЭЛ

1	Компаний оноосон нэр	ЖУУЛЧИН ГОВЬ ХК
2	Компаний удирдлага	Б.Гантулга Харилцах утас:11-345959.88113389
3	Компаний хаяг	Өмнөговь аймаг Хан хонгор сум Мандах баг ХУД 2-р хороо Чингисийн өргөн чөлөө
4	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	
5	РЕГИСТРИЙН ДУГААР	2016273
6	Бүргэгдсэн он сар өдөр	2014 он
7	Үйл ажиллагааны чиглэл	АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ
8	Санхүү	Ерөнхий санхүүч:П.Мөнгөнцэцэг Харилцах утас:86100608
9	Ажилчдын тоо	14
10	Аудитын компани	"Ай Жэй Эй Эйч-аудит" ХХК Нягтлан бодох бүртгэл, татвар, санхүүгийн хяналт баталгаажуулалтын итгэмжлэгдсэн хөндлөнгийн байгууллага
11	Аудитын компаний хаяг	Монгол улс: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 14-р хороо Борх төв 310,311 тоот Харилцах утас:976-11450279 Факс:976-11450279



“ЖУУЛЧИН ГОВЬ”ХК-ний

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Мянган төгрөг

	2018	2019	
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө	3659.8	38168.0	
Дансны авалга			
Татвар НДШ авалга	303.9		
Бусад авалга	3.5		
Бараа материал			
Урьдчилж төлсөн зардал			
Бусад эргэлтийн хөрөнгө	38811.9	38811.9	
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>42779.1</b>	<b>76979.9</b>	
Үндсэн хөрөнгө	314626.4	300203.2	
Биет бус хөрөнгө			
Эргэлтийн бус бусад хөрөнгө			
Дуусаагүй барилга			
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>314626.4</b>	<b>300203.2</b>	
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>357405.5</b>	<b>377183.1</b>	
Дансны өглөг	127626.1	313310.0	
Татварын өглөг	3604.2	1502.2	
Бусад богино хугацаат өр			
Банкны богино хугацаат зээл	200000.0		
Урьдчилж орсон орлого			
<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>331230.3</b>	<b>314812.2</b>	
Өмч	94169.0	94169.0	
Хөрөнгийн дахин үнэлгээ	22567.2	22567.2	
Өмчийн бусад хэсэг			
Хуримтлагдсан ашиг	(90561.0)	(54365.3)	
<b>Өмчийн дүн</b>	<b>26175.2</b>	<b>62370.9</b>	
<b>Өр төлбөр өмчийн дүн</b>	<b>357405.5</b>	<b>377183.1</b>	

2020.03.31

1,010,000

2020.03.31

1,010,000

2020.03.31

1,010,000

2020.03.31

1,010,000

Нийт хөрөнгийн дүн (үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгө, өмчийн хөрөнгө, өмчийн бусад хэсэг, хуримтлагдсан ашиг) нь 357,405.5 (2019 оны 12 сарын 31-ийн төгсгөл) болон 377,183.1 (2019 оны 12 сарын 31-ийн төгсгөл) байна. Өр төлбөрийн дүн (банкны богино хугацаат зээл, өр төлбөр) нь 331,230.3 (2019 оны 12 сарын 31-ийн төгсгөл) болон 314,812.2 (2019 оны 12 сарын 31-ийн төгсгөл) байна.



## “ЖУУЛЧИН ГОВЬ” ХХК

### ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

(мян.төгрөгөөр)

	Хувьцаат капитал	Өмчийн бусад хэсэг	Хуримтлагд сан ашиг	Нийт дүн
<b>2018 оны 01 сарын 31</b>	<b>94169.0</b>	22567.2	(90561.0)	26175.2
Бүртгэлийн ажиллагааны залруулга				
<b>Залруулсан үлдэгдэл</b>				
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал			36195.7	
Зарласан ногдол ашиг				
<b>2019 оны 12 сарын 31</b>	<b>94169.0</b>	<b>22567.2</b>	<b>(54365.3)</b>	62370.9

*Нэмэлт тодруулууд нь эдгээр санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно.*

### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

мянган.төгрөгөөр)

	2018	2019
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	157234.4	266719.5
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого</b>	<b>157234.4</b>	<b>265176.8</b>
Борлуулалтын болон худалдан авагчдаас орсон мөнгө		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Бусад мөнгөн орлого		1542.6
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	<b>167969.5</b>	<b>215036.1</b>
Ажиллагчдад олгосон мөнгө	30628.8	39210.3
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	9024.4	10523.8
Түүхий, эд материал худалдан авахад төлсөн мөнгө	46160.5	65660.9
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	1268.0	2547.2
Түлш шатахуун	10812.6	18221.3
Төлсөн татвар	13124.9	<b>30429.5</b>
Бусад мөнгөн зардал	57460.2	48443.1



Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(10735.0)	51683.4
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Бусадад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Бусад		
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Бусад олгосон зээл урьдчилгаа		
Бусад		
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(36711.6)	(7858.9)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
Хүү ба урамшууллын орлого		
Валютын ханшын зөрүү		
Төлсөн ногдол ашиг		
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2944.0)	(9316.2)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(50390.6)	34508.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	54050.4	3659.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3659.8	38168.0

Гүйлгээ баланс, ерөнхий журнал, бэлэн мөнгөний гүйлгээ журнал, өр, авалгын тооцоо нийлсэн актыг [jjah\\_audit\\_2008@yahoo.com](mailto:jjah_audit_2008@yahoo.com) Э-майлаар илгээнэ

Аудитын тайланг гаргасан Хугацаагүй эрхт мэрэгшсэн нягтлан бодогч

Харилцах утас: 99290785 Т.Очирбат

Аудитын тайланг хүлээн зөвшөөрсөн санхүүч  

Харилцах утас: 86100608



Аудитын гэрээт ажлын захидал  
“ЖУУЛЧИН ГОВЬ” ХХК-ийн захирал Д.Ган эрдэнэ танаа  
2020 оны 02-р сарын 01-ний өдөр Улаанбаатар хот

Монгол улсын “Аудитын тухай” хуульд зааснаар танай байгууллагын 2019 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаарх баланс, уг өдрөөр дуусгавар болсон орлого үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийлгэх тухай хүсэлт тавьсан билээ. Танай хүсэлтийг хүлээн авсныг болон энэхүү гэрээт ажлын талаарх өөрсдийн ойлголтыг бид энэ захидлаар баталгаажуулахыг хүсч байгаагаа илэрхийлэхэд таатай байна. Манай талаас үзүүлэх аудитын үйлчилгээний зорилго нь санхүүгийн тайлангуудад дүгнэлт өгөх явдал юм.

Бид аудитыг Аудитын Олон улсын стандартын дагуу явуулна. Санхүүгийн тайлангууд материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэдэг үндэслэлтэй нотолгоог олж авах зорилгоор аудитын ажлыг төлөвлөж гүйцэтгэхийг АОУС-Стандарт-д заасан байдаг. Аудитын явцад санхүүгийн тайлан дахь дүн нэмэлт тодруулгууд нь зөв эсэхийг нотлоход тестийн арга хэрэглэнэ. Түүнчлэн тухайн байгууллагад хэрэглэгдэж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд удирдлагын хийсэн томоохон хэмжээний тооцооллууд, санхүүгийн тайлагналын байдалд бүхэлд нь үнэлэлт өгнө.

Сорилын мөн чанар аудитын бусад уламжлалт хязгаарлалтууд түүнчлэн НББ-ийн болон дотоод хяналтын тогтолцооны бусад уламжлалт хязгаарлалтуудаас шалтгаалж зарим материаллаг буруу илэрхийлэл илрэлгүй үлдэж ч болох гарцаагүй эрсдэл байдаг.

Бид санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг хүргүүлэхээс гадна нягтлан бодох бүртгэл ба дотоод хяналтын системд байгаа аливаа материаллаг сул талыг тусад нь менежментийн захидлаар танай талд мэдэгдэх болно. (Энэхүү захидалд аудитын явцад ажиглагдсан сул талуудын үндсэн дээр дотоод хяналтын системийг сайжруулах талаар өгөх зөвлөмжүүдийг тусгана. Гэвч үүнийг дотоод хяналтын бүтцийн үр ашигтай байдлыг бүхэлд нь дүгнэсэн тусгай дүгнэлт гэж ойлгож болохгүй. Учир нь энэ нь санхүүгийн тайлангийн хүрээнд гаднах асуудал юм.)

Аудитын явцад бидний бэлтгэсэн ажлын баримтууд нь бидний өмг бөгөөд нууц шинж чанартай байна. Эдгээрийг бид дотоод стандарт, дүрэм, журмын дагуу өөрсдөө хадгалах болно.

Бид танай байгууллагатай хамтран ажиллах чин эрмэлзэлтэй байгаа бөгөөд аудиттай холбоотой бидний хүссэн аливаа бүртгэл баримт бусад мэдээллээр биднийг хангана гэдэгт итгэлтэй байна.


Зохих нэмэлт тодруулга бүхий санхүүгийн тайланг бэлтгэх нь тухайн байгууллагын удирдлагын хүлээх хариуцлага гэдгийг бид сануулахыг хүсч байна. Үүнд: нягтлан бодох бүртгэлийн зохих бичилт болон дотоод хяналтыг, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгож хэрэглэх, байгууллагын хөрөнгийг найдвартайгаар хадгалах зэрэг зүйлс багтана.


Аудиттай холбогдуулан гаргасан удирдлагын хариуцлагын захидлыг бичгээр баталгаажуулахыг бид хүсч байна.

Ажлын явцад бидний нэхэмжлэх хөлс нь ажилд оролцож буй хүн бүрийн хувьд шаардагдах цагт үндэслэх бөгөөд дээр нь халаасны зардал нэмэгдэнэ. Хүн тус бүрийн хувьд цагийн хөлс нь тэдний хүлээх үүрэг хариуцлага, шаардагдах туршлага, үр чадвараас хамаарч харилцан адилгүй байна.


Энэ захидал цуцлагдаагүй, нэмэлт өөрчлөлт ороогүй, өөр захидлаар солигдоогүй бол дараагийн жилүүдэд хүчин төгөлдөр байна.

Санхүүгийн тайланд бидний хийх аултын ажлыг зохион байгуулах талаархи та бүхний ойлголттой нийцэж байгаагийн илэрхийлэл болгож энэхүү захидлын хавсралт хувь дээр гарын үсгээ зурж баталгаажуулан, буцаан ирүүлнэ үү.



“Ай Жэй Эй Айч-Аудит” ХХК-ийн захирал  / Г.Энхмаа /

Танилцаж зөвшөөрсөн:

“ЖУУЛЧИН ГОВЬ” ХХК-ий захирал  / Б.Гантулга /





## ЖУУЛЧИН ГОВЬ ХК

Удирдлагын хариуцлагын захидал

“Ай Жэй Эй Эйч аудит” ХХКомпанийн

Ерөнхий захирал Г.Энхмаад

Огноо: 2020-02-02

“ЖУУЛЧИН ГОВЬ” ХК-ийн санхүүгийн тайлангууд нь 2019 оны 12 сарын 31 нээрх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн ба шударгаар ( эсвэл бүх материаллаг зүйлсийн хувьд шударгаар) илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх зорилгоор 2019 оны 12 сарын 31 нээр тасалбар болсон. “ЖУУЛЧИН ГОВЬ” ХК-ийн санхүүгийн тайланд хийж буй танай аудитын ажилтай холбогдуулан энэхүү танилцуулгыг өгч байгаа юм.

Олон Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын дагуу санхүүгийн тайлангаа шударгаар илэрхийлэх нь бидний үүрэг хариуцлага гэдгийг бид хүлээн зөвшөөрч байна.

Бид өөрсдийн мэдэж байгаа зүйлс болон итгэл найдвартаа үндэслэн дараахь танилцуулгыг хийж байна.

- Нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын ситемд чухал үүргийг гүйцэтгэдэг удирдлага, болон ажиллагчид ер бусын дутагдалтай зүйлс буюу санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхүйц зөрчилтэй зүйлд оролцоогүй
- Бид та бүхэнд бүх данс бүртгэлийн журналууд, туслах нотлох баримт бичгүүд болон даргын тушаал, хурлын протоколыг ( нэр болон он сар өдрөөр нь) гаргаж өгсөн
- Санхүүгийн тайланд материаллаг зөрчилтэй зүйл болон хаяж орхигдуулсан зүйл байхгүй.
- Санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй байх гэрээ хэлцлүүдийн нөхцлийг компани биелүүлж байна. Мөн санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхээргүй засаг захиргааны эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм журмыг дагаж мөрдөж байгаа
- Санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгийн өртөг ба ангилал, өрийн үлдэгдлийг материаллагаар өөрчлөх төлөвлөгөө, зорилго бидэнд байхгүй
- Цэвэр боломжит үнэ цэнээс дээгүүр үнээр илэрхийлэгдсэн бараа материал үгүй болно.
- Тус газар нь бүх хөрөнгөө эзэмшиж байгаа бөгөөд хөрөнгө битүүмжилсэн гэх зэрэг аливаа төвөг үгүй болно.
- (Тайлант жилийн хугацаанд компани ямар нэгэн өмгөөлөгчид хандаагүй бол “Бид шүүх заргатай холбоотой ямар нэгэн нэхэмжлэл хүлээж аваагүй бөгөөд санхүүгийн тайланд тодруулга болгох шаардлагагүй болон энэ хэргийн талаар бид хуульчид хандаагүй болно” гэж тусгах хэрэгтэй)
- Манай мөнгө ба хөрөнгө оруулалтын дансдын дотор зээл нөхөх албан ёсны ба албан ёсны бус сан байхгүй болно.

Захирал



//